





Бүртгэлтэй хувьцаат компанийн мэдээлэл, тайлагнал

2020 ОНЫ 9 САР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛУУД



2020 оны 9 сарын 7-ны байдлаар



₮2.58
Тэрбум

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

ТОП-20 ИНДЕКС

17,049.27



54
ГИШҮҮН

БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИ

199

АНГИЛАЛ 1 18

АНГИЛАЛ 2

АНГИЛАЛ 3

139


42

100% төрийн өмчит компани 18

Төрийн өмчийн оролцоотой 10

ТОП-20 индекс I 2016 vs 2020

2016 онтой харьцуулахад
2020.09.07 36.9% ▲




Зах зээлийн үнэлгээ I 2016 vs 2020

2016 онтой харьцуулахад
2020.09.07 75.1% ▲



Монголын хөрөнгийн биржийн арилжаа | 1995-2020.09.07

Нийт 3.3 их наяд төгрөг



Үнэт цаасаа олон нийтэд санал болгон хөрөнгө татан төвлөрүүлсэн компаниуд I 2016-2020.09.07



2016-2020 онд нийт **16 шинэ** үнэт цаас бүртгэгдэж, нийт **97.7** тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Үүнээс **2020 онд:**

Компани	Хөрөнгө, тэрбум төг
Анхдагч зах зээлд арилжигдсан:	
"Бодь даатгал" ХК	5.3
"Лэндмн ББСБ" ХК – Ленд Бонд	5.0
Нийт	10.3
Удахгүй арилжигдах:	
"Сүү" ХК – нэмэлт үнэт цаас	18.5
Үндэсний хувьчлалын сангийн нэгж эрх	5.0
Шалгагдаж байгаа:	
1 бонд, 1 IPO, 1 ХБҮЦ	16.9
	40.4

Үндсэн зохицуулж буй хуулиуд

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
2. Компанийн тухай хууль
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

СЗХ болон МХБ-ийн журам, заавар

1. Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам /2015.12.17/
2. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам /2018.12.14/
3. МХБ-ийн бүтгэлийн журам түүний хавсралт Бүртгэлийн гэрээ /2018.01.25/
4. Үнэт цаас гаргагчаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар /2017.04.28/

- Зорилго нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих
- Журмын 1.6–д энэхүү журмын хэрэгжилтэнд Хөрөнгийн бирж хяналт тавьж ажиллах бөгөөд хөрөнгийн бирж шаардлагатай гэж үзвэл өөрийн бүртгэлийн ангилал, шалгуурт тохирсон мэдээллийн ил тод байдлыг хангуулахтай холбоотой нарийн дүрэм, журам тогтоож болно.
- 4.11-д Мэдээллийг зохих журмын дагуу нийтэд хүргэх үүргийг биелүүлээгүй компанид Хөрөнгийн бирж зөрчил гарсанаас хойш ажлын 10 өдөрт багтаан шаардлага хүргүүлэх бөгөөд зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд энэ талаарх мэдээллийг Хороонд хүргүүлэнэ.
- 6.1-д Хороо энэ журмын 4.11-д заасны дагуу Хөрөнгийн биржээс ирүүлсэн мэдээллийг холбогдох журмын дагуу хянаж компанийн удирдлагаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу зөрчлийг арилгуулж, холбогдох захиргааны хариуцлага ногдуулна.
- Тогтмол болон тухай бүр ирүүлэх 30 гаран мэдээллийг тусгаж өгсөн.

- Зорилго нь: Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарт арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хувьцаат компаниудын мэдээллийг түргэн шуурхай, хялбар аргаар хүргэх
- Холбогдох хууль болон СЗХ-ны дүрэм, журмаар тогтоосон олон нийтэд тогтмол болон тухай бүр хүргэх ёстой мэдээллийг жагсаалтыг 19 маягтаар биржид цахим болон цаасан хэлбэрээр ирүүлэх боломжийг олгосон. www.mse.mn/

Үнэт цаас гаргагчаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар /МХБ/

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 оны хагас жил
1	ХЭХ-ын мэдэгдэл ирүүлсэн	137	151	142
2	Хурлын материал ирүүлсэн	124	131	128
3	Жилийн эцсийн санхүүгийн тайлан ирүүлсэн	130	138	132
4	Аудитын дүгнэлт	82	87	95
5	Үйл ажиллагааны тайлан ирүүлэлт	77	83	92
6	Цахим хуудастай эсэх	60	53	57
7	Бүртгэлийн хураамж төлөлт	100	118	84
8	Ногдол ашгийн шийдвэр	97	117	112
9	Хагас жилийн санхүүгийн тайлан	78	88	98
10	Хагас жилийн үйл ажиллагааны тайлан	43	51	54

Бүртгэлтэй компаниудын үүргийн хэрэгжилт /МХБ/

1. ХЭХ-ын мэдэгдэл ирүүлсэн
2. Хурлын материал ирүүлсэн
3. Жилийн эцсийн санхүүгийн тайлан ирүүлсэн
4. Аудитын дүгнэлт
5. Үйл ажиллагааны тайлан ирүүлэлт
6. Цахим хуудастай эсэх
7. Бүртгэлийн хураамж төлөлт
8. Ногдол ашгийн шийдвэр
9. Хагас жилийн санхүүгийн тайлан
10. Хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Үүргийн хэрэгжилт /хувь/	2017 он	2018 он	2019 он	2019 оны хагас жил
90-100 хувь /Бүрэн/	36	39	44	55
71-89 хувь /Бүрэн бус/	43	34	35	28
50-69 хувь /Бүрэн бус/	30	34	42	48
49 хувиас доош /Хангалтгүй/	88	89	56	46
Нийт	197	196	177	177

№	Тогтмол ирүүлэх мэдээллийн төрөл	Хууль, журмын заалт	Хугацаа
1	Жилийн эцсийн санхүүгийн тайлан	ҮЦЗЗТХ 20.1.6, НББ хуулийн 10.3	02 сарын 10 -ны дотор /компанийн нэгдэл 03.01/
2	Ногдол ашиг тараах эсэх тухай шийдвэр	КТХ-ийн 46.5	Санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор буюу 02 сарын 19 -ны дотор
3	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл	КТХ-ийн 60.3, 60.4, СЗХ-ны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 3.1	03 сарын 21 -ны дотор +/3-5 хоног/
4	Аудитын дүгнэлт	ҮЦЗЗТХ 20.1.6, Аудитын тухай хуулийн 10.2, НББ хууль 9.7	ХЭХ-аас 2-оос доошгүй долоо хоногийн өмнө /ТӨХК 03.15 , Банк 03.31 /
5	Жилийн үйл ажиллагааны тайлан*	СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 2.2	03 сарын 31 -ний дотор /04.01-ний дотор/
6	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл	КТХ-ийн 74.1, ҮЦЗЗТХ 20.1.8, 56.1.6, 56.2.3, СЗХ-ны "ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журам"-ын 2.10	Хурал хуралдсанаас хойш ажлын 3-15 өдрийн дотор

2 дугаар улирал

№	Тогтмол ирүүлэх мэдээллийн төрөл	Хууль, журмын заалт	Хугацаа
1	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах сүүлчийн хугацаа	КТХ-ийн 59.4	04 сарын 30 -ны дотор
2	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл	КТХ-ийн 74.1, ҮЦЗЗТХ 20.1.8, 56.1.6, 56.2.3, СЗХ-ны "ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журам"-ын 2.12	Хурал хуралдсанаас хойш ажлын 3-15 өдрийн дотор /сүүлчийн хугацаа 05 сарын 20 /

3 дугаар улирал

№	Тогтмол ирүүлэх мэдээллийн төрөл	Хууль, журмын заалт	Хугацаа
1	Хагас жилийн санхүүгийн тайлан	НББ хуулийн 10.3, СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 1.7	07 сарын 20 -ны дотор
2	Хагас жилийн үйл ажиллагааны тайлан*	СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 2.2, 2.4	08 сарын 01 -ний дотор

Бусад

№	Мэдээллийн төрөл	Хууль, журмын заалт	Хугацаа
1	Тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл	ҮЦЗЗТХ-56.1, 56.2, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам”-ын 3-р зүйл, 3.2	Тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын 1 өдрийн дотор
2	Ногдол ашиг хуваарилалтын тайланг ХЭХ-д тайлагнах, МХБ-д ирүүлэх	КТХ 46.14 КТХ 46.15	ХЭХ-ын өдөр/хуваарилж дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор
3	Жилийн үйлчилгээний хөлс төлөх	МХБ-ийн Бүртгэлийн журам 22.11, Бүртгэлийн гэрээ 2.1.3, 2.4	03 сарын 31 -ний дотор

Санал, зөвлөмж

- МХБ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүрэгээ биелүүлэн ажиллах /Жил бүрийн эхэнд ирүүлсэн албан бичгийн дагуу хугацаат болон хугацаат бус мэдээллийг ирүүлэх, тайлбар хүргүүлэх/
- Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийг мэргэшүүлэх, СЗХ болон МХБ-ийн компани хариуцсан мэргэжилтэнтэй байнгын харилцаатай байх
- СЗХ болон МХБ-ийн дүрэм, журам болон нээлттэй хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийг гүйцэтгэлийг сайтан биелүүлэх

Анхаарал тавьсанд баярлалаа.

Mongolian Stock Exchange
Sukhbaatar square - 3, Ulaanbaatar, Mongolia
Tel: (976)-11-310 501
Fax: (976)-11-325 170
www.MSE.mn